



Монголбанк

Санхүүгийн мэдээллийн алба

Мөнгө угаах ТИПОЛОГИЙН жишээ кейсүүд

2020 он

Мөнгө угаах типологийн жишээ кэйсүүдийг мэдээлэх үүрэгтэй этгээдийн сэжигтэй гүйлгээг илрүүлж, мэдээлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор бусад улсын типологийн жишээ кэйсүүдээс орчуулан зөвхөн албан хэрэгцээнд зориулан гаргасан болно.

Хэвлэн нийтлэх, олон нийтэд тараахыг хориглоно.

©2020 Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба

Санхүүгийн мэдээллийн алба
Бага тойруу-3, 15160
Улаанбаатар-46, Монгол Улс
Утас: 976-11-326161, 976-11-321199
Факс: 976-11-311471
E-mail: fiu@mongolbank.mn

2020.07.29

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|-------|--|
| БМГТ | Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан |
| ГТТГ | Гадаад төлбөр тооцооны гүйлгээ |
| ГТТГТ | Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан |
| МУТС | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх |
| МҮЭ | Мэдээлэх үүрэгтэй этгээд |
| СГТ | Сэжигтэй гүйлгээний тайлан |
| СМА | Санхүүгийн мэдээллийн алба |
| ҮХХ | Үл хөдлөх хөрөнгө |
| ХСБ | Хууль сахиулах байгууллага |

Кэйс 1 – Санхүүгийн мэдээллийн албаны мэдээлэл цахим санхүүгийн залилангийн хэргийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлэв.

Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-ны шилжүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлан (СГТ)-нд үндэслэн залилан, цахим гэмт хэрэгт холбогдуулан олон улсад эрэн сурвалжилж байсан иргэн А-г баривчилсан бөгөөд тэрээр санхүүгийн залилан цахимаар хийснээ болон мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутай гэдгээ хүлээн зөвшөөрсөн байна.

Иргэн А нь 5 жил 10 сарын хорих ялаар шийтгүүлж, эрх бүхий байгууллагуудтай залилагдсан, алдагдсан хөрөнгийг эргүүлэн олоход хамтрахаар болсон байна.

Хууль сахиулах байгууллагууд иргэн А-г иргэдийг луйврын аргаар залилан мэхэлж, 30 сая орчим долларын хохирол учруулсан зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлийн гишүүн гэж үзэн эрэн сурвалжилж байсан байна. Хууль сахиулах байгууллага (ХСБ)-ууд сэжигтний мэдээллийг олон нийт болон гадаад улсын эрх бүхий байгууллагад сэрэмжлүүлэх зорилгоор цахим орчинд нийтэлсэн байв.

Мэдээлэх үүрэгтэй этгээд (МҮЭ)-ээс иргэн А-тай холбоотой гурван СГТ СМА-нд мэдээлсэн бөгөөд иргэн А хэд хэдэн өөр нэрээр гүйлгээ хийсэн талаар дурдсан байв. Энэ СГТ-нд СМА дүн шинжилгээ хийж хууль сахиулах байгууллагад шилжүүлсэн ба энэ нь ХСБ-д сэжигтнийг илрүүлэхэд онцгой дэмжлэг үзүүлсэн байна.

СМА-ны хийсэн дүн шинжилгээгээр иргэн А нь тус улсад үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн арилжааны банкинд хуурамч бичиг баримт ашиглан өөр өөр нэрээр данс нээлгэсэн, гуравдагч этгээдтэй хамтран данс эзэмшдэг, мөн өөрийн ажиллуулдаг зоогийн газрын нэр дээр бизнесийн данс эзэмшдэг болохыг тогтоов. МҮЭ-ээс ирүүлсэн тайлан дээрх гүйлгээний утгыг доор нарийвчлан харуулав. Үүнд:

Гадаад төлбөр тооцооны гүйлгээ (ГТТГ)

СГТ-нд иргэн А нь Х банкин дахь өөрийн дансандаа 1.5 сая долларыг гадаад гүйлгээгээр хүлээн авсан тухай тэмдэглэсэн байв. Эдгээр гүйлгээг нэг сарын хугацаанд Хонконгоос хэд хэдэн өөр хүн, хуулийн этгээд шилжүүлсэн байв. Үүнээс гадна Канад улсаас 185,000 долларыг мөн гадаад гүйлгээгээр хүлээн авсан мэдээлэл дурдагдсан байна.

СМА-ны дүн шинжилгээгээр иргэн А-ийн дансанд гадаад улсаас сүүлийн нэг жилийн хугацаанд Канад, Хонконг, Индонез, Нигери, Арабын Нэгдсэн Эмират улсуудаас тус бүр 30,000-765,000 долларын гүйлгээгээр, нийт 6,6 сая доллар хүлээн авсан болохыг тогтоосон байна.

Иргэн А-ийн хүлээн авсан 6.6 сая доллараас 2.6 сая долларыг Хонконг, Канад, Нигери улсуудаас түүний хувийн данс руу шилжүүлсэн байна. Харин тухайн иргэний эзэмшдэг компанийн данс руу Хонконг, Индонез, Нигери, Арабын Нэгдсэн Эмират улсуудаас ойролцоогоор 4 сая долларыг шилжүүлсэн бөгөөд тус гүйлгээнүүд нь иргэн А-ийн ажиллуулдаг зоогийн газрын бизнесийн үйл ажиллагаатай нийцэхгүй байв.

СГТ-нд мэдээлснээр иргэн А нь гадаадаас орлогын гүйлгээ хүлээн авсны дараа олон янзын аргаар бэлэн мөнгө болгон зарлагаддаг байв. Үүнд:

- » хоёр өөр хотын банкны салбаруудаас бэлнээр авсан;
- » тоглоомын газрууд дахь АТМ-аас бэлнээр авсан;
- » дебит карт ашиглан өндөр үнэ бүхий бараа худалдаж авсан. Үүнд:
 - 50,000 долларын үнэтэй тансаг зэрэглэлийн машин;
 - 95,000 долларын үнэт эдлэл;
- » үл хөдлөх хөрөнгийн зуучлагчид 195,000 долларыг банкны чекээр төлсөн байна.

Иргэн А нь АНУ, Канад, Герман, Люксембург, Малайз зэрэг улсууд руу тус бүр нь 20-245,000 долларын дүнтэй, нийт 318,000 долларыг шилжүүлсэн бөгөөд үүнээс 245,000 долларыг “ипотекийн төлбөр” гэх утгатайгаар Канад улс руу шилжүүлсэн байна.

Өндөр дүнтэй гадаад гүйлгээ болон бэлнээр хийж буй зарлагын гүйлгээ нь харилцагчийн бизнесийн үйл ажиллагаатай тохирохгүй байгаа нь түүнийг сэжиглэх үндэслэл болж байгааг СГТ-нд тэмдэглэсэн байв.

Бэлэн мөнгөөр хийсэн зарлага

СГТ-д иргэн А-ийн данснаас өндөр дүнтэй, их хэмжээний бэлэн мөнгөний зарлага гарсныг тэмдэглэсэн байна:

- » банкны өөр өөр салбар, нэгжүүдээс 10 сарын турш 1,000-57,000 долларын дүнгээр найман удаагийн үйлдлээр нийт 94,000 долларыг бэлнээр авсан;
- » Богино хугацаанд банкны олон салбараар үйлчлүүлэн бэлнээр зарлагын гүйлгээ хийсэн:
 - Найман өдрийн турш 6,500-9,500 доллар хүртэлх дүнгээр гурван удаа, нийт 25,000 доллар бэлнээр авсан;
 - Банкны өөр өөр салбар, нэгжүүдээс хоёр сарын турш 5,000-9,700 доллар хүртэлх дүнгээр 15-аас дээш удаагийн давтамжтайгаар нийт 128,000 долларыг бэлнээр авсан байна.

Бэлэн мөнгөөр хийсэн дээрх зарлагын гүйлгээг Бэлэн мөнгөний гүйлгээний тайланг (БМГТ)-аар мэдээлэгдэхээс зайлсхийх зорилгоор тайланг мэдээлэх дүнгийн доод хязгаар болох 10,000 долларт хүргэхгүйгээр хийсэн байж болзошгүй байв. Үүнд:

- » Банкны нэг салбараас нэг өдрийн дотор 8 удаа тус бүр 1,000 долларыг бэлнээр авсан;
- » 3 сарын турш 80-2,000 доллар хүртэлх дүнгээр 100 гаруй удаагийн гүйлгээгээр нийт 105,000 долларыг бэлнээр авсан байна.

Бэлэн мөнгөөр хийсэн орлого

СГТ-нд банкны хэд хэдэн салбаруудад хийсэн бэлэн мөнгөний орлогын гүйлгээний талаар дэлгэрэнгүй тэмдэглэсэн байснаас дурдвал:

- » Банкны хоёр өөр салбарт өөр өдрүүдэд 8,500 доллар болон 32,000 долларын бэлэн орлого хийсэн;
- » 3 сарын турш 3,000-23,000 доллар хүртэлх дүнгээр, нийт 56,000 долларын бэлэн орлого хийсэн;
- » 10 сарын турш банкны өөр өөр салбар, нэгжид 45-65,000 доллар хүртэлх дүнгээр нийт 105,000 долларын бэлэн орлого хийсэн байв.

Дотоодын цахим шилжүүлэг

СГТ-нд иргэн А-гийн данс хооронд хийгдсэн олон тооны, өндөр дүнтэй дотоодын цахим шилжүүлгийг нарийвчлан тусгасан байв. Үүнд:

- » иргэн А-гийн данс хооронд 2 сарын хугацаанд хийгдсэн нийт 1,3 сая долларын дотоод шилжүүлэг;
- » иргэн А-ийн бусадтай хамтран эзэмшдэг данснаас түүний хувийн данс руу нь 3 сарын хугацаанд хийгдсэн 1,5 сая долларын шилжүүлэг;
- » гуравдагч этгээдээс иргэн А-д ирсэн болон гарсан шилжүүлэг:
 - иргэн А-гийн данснаас 3 сарын хугацаанд 140,000-1,2 сая доллараар 75 удаагийн давтамжтай хийгдсэн нийт 7,2 сая долларын шилжүүлэг;
 - гуравдагч этгээдээс 3 сарын хугацаанд 400-1,2 сая доллараар нийт 7.2 сая долларыг хүлээн авсан байв.

СГТ-н эрх бүхий байгууллагад шилжүүлэг

СМА нь СГТ-нд дүн шинжилгээ хийсний дараа эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлсэн бөгөөд тус мэдээллийг ашиглан иргэн А-г хуурамч бичиг баримт ашиглаж байсныг илрүүлсэн байна.

МҮЭ-ээс нэмж ирүүлсэн СГТ-ууд нь өмнөх СГТ-тай төстэй бөгөөд иргэн А-гийн дараах санхүүгийн үйл ажиллагааны талаар нарийвчлан дурджээ. Үүнд:


- » Казино болон бусад тоглоомын газруудын дансанд 25,000 доллар болон 60,000 доллараар 2 удаа дотоодын цахим шилжүүлэг хийсэн;
- » Казинод 6 удаа очихдоо нийт 275,000 долларын тоглоомын чип худалдан авсан бөгөөд нийт алдагдал нь 53,700 доллар болсон;
- » Иргэн А нь нийт 9,000 долларын үнэтэй казиногийн чипийг янз бүрийн аргаар бэлэн мөнгө болгосон бөгөөд казинод бичиг баримтаа үзүүлэхээс татгалзсан;
- » 2 сарын хугацаанд тоглоомын газруудад нийт 175,000 долларын бооцоо тавьсан талаар тус тус дурдсан байна.

СМА болон ХСБ-ын хийсэн дүн шинжилгээгээр иргэн А-гийн хэн болохыг тогтоож бататгасан төдийгүй СМА-наас шилжүүлсэн мэдээлэл нь иргэн А-ийн ашигладаг утасны дугаар, хаягийн мэдээллийг өгснөөр түүнийг олж тогтооход дэмжлэг болсон байна. Түүнчлэн СМА-ны мэдээлэл нь эрх бүхий байгууллагад иргэн А-гийн санхүүгийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй зураглал, мэдээлэлтэй болоход тус болсон байна.

ХСБ иргэн А-г баривчилсан бөгөөд шүүхээс түүнд 5 жил 10 сарын хорих ял оноосон байна. Иргэн А нь санхүүгийн залилан цахимаар үйлдсэн болон мөнгө угаах гэмт хэрэгт гэм буруутай гэдгээ хүлээн зөвшөөрч, алдагдсан хөрөнгийг буцаахад эрх бүхий байгууллагуудтай хамтрахаар тохиролцсон байна.

| | |
|------------------------------|---|
| Үйлдсэн гэмт хэрэг | <ul style="list-style-type: none"> ○ Мөнгө угаах ○ Залилан |
| Харилцагч | <ul style="list-style-type: none"> ○ Аж ахуй нэгж ○ Хувь хүн |
| МҮЭ | <ul style="list-style-type: none"> ○ Банк ○ Казино |
| Суваг | <ul style="list-style-type: none"> ○ Цахим ○ Биет |
| Тайлангийн төрөл | <ul style="list-style-type: none"> ○ ГТТГТ ○ СГТ |
| Холбогдсон улс орнууд | <ul style="list-style-type: none"> ○ Дотоод ○ Гадаад – Канад, Герман, Хонконг, Индонез, Люксембург, Нигери, Арабын Нэгдсэн Эмират улс |
| Ашигласан үйлчилгээ | <ul style="list-style-type: none"> ○ Харилцах, хадгаламжийн үйлчилгээ ○ Мөрийтэй тоглоомын үйлчилгээ |
| Шалгуур үзүүлэлт | <ul style="list-style-type: none"> • Дансаар хийсэн гүйлгээнүүд нь тухайн хүний хийдэг гүйлгээний хэв маяг, бизнесийн үйл ажиллагаатай нийцээгүй; • Богино хугацаанд банкны салбаруудад өндөр дүнтэй бэлэн мөнгөөр орлого хийсэн; • Казиногийн үнэтэй чипийг бэлэн мөнгөөр худалдан авсан; • Казино, тоглоомын газрын дансанд өндөр дүнгээр шилжүүлэг хийсэн; • Тодорхой шалтгаангүйгээр өндөр дүнтэй гадаад шилжүүлэг хийсэн; • Банкны салбар болон АТМ-аас их хэмжээний бэлэн мөнгө авсан; • Өндөр эрсдэлтэй улсаас шилжүүлэг хүлээн авсан; • Богино хугацаанд казинод их хэмжээний бэлэн мөнгөөр бооцоо тавьсан; • МҮЭ-ээс гүйлгээ мэдээлэх босго дүн (10,000 доллар)-ээс доогуур дүнтэй бэлэн мөнгө олон удаа авсан; • АТМ болон банкны салбараас нэг өдөрт их хэмжээний бэлэн мөнгө авсан; • Гадагшаа ипотекийн зээлийг төлөхөд зориулсан гэх утгатайгаар шилжүүлэг хийсэн; • Тоглоомын чипийг бэлэн мөнгөөр худалдаж авахдаа бичиг баримтаа үзүүлэхээс татгалзсан; • Богино хугацааны дотор их хэмжээний бэлэн мөнгө авсан; • Тодорхой шалтгаангүйгээр гуравдагч этгээдийн данс руу шилжүүлэг хийсэн; • Дебит карт ашиглан өндөр үнэтэй худалдан авалт хийсэн. |

Зураг 1: Кейс 1 – СМА-ны мэдээлэл нь цахим гэмт хэргийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлэв.



Кэйс 2 – Хонконг, Шинэ Зеланд Улсаар дамжуулан мөнгө угаасан нягтлан бодогчийг илрүүлэв.

ХСБ-аас иргэн Б-г мөнгө угаасан хэрэгт сэжиглэн мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ. СМА-ны мэдээллээс иргэн Б-г хэд хэдэн хуулийн этгээдтэй холбоотой, мөн гүйлгээг мэдээлэх доод хязгаараас доогуур дүнгээр бэлэн орлого тушаах зохион байгуулалттай схем (structured cash deposit)-д оролцсон байж болзошгүй нөхцөл байдлыг илрүүлсэн бөгөөд шүүхээс уг иргэнийг санхүүгийн гүйлгээ хийхдээ санаатайгаар мэдээлэл нуун дарагдуулсныг тогтоосон байна.

Иргэн Б-ийн данс руу хоёр жилийн хугацаанд гүйлгээг мэдээлэх доод хязгаараас бага дүнгээр 80 гаруй бэлэн мөнгөний орлого болон чекээр хийсэн орлогын гүйлгээ хийсэн байв. Иргэн Б нь нягтлан бодогч бөгөөд дээр дурдсан орлогын гүйлгээнүүдийг хүлээн авмагц мөнгөний ихэнх хэсгийг цахимаар гуравдагч этгээдийн данс руу шилжүүлж, орлогын тодорхой хувийг ажлын хөлс болгон өөрөө авдаг болохыг тогтоожээ.

Иргэн Б-ийн хүлээн авч шилжүүлсэн мөнгөний эх үүсвэр нь тодорхойгүй байгаа ч тус улсад хууль бусаар нэвтрүүлсэн хар тамхины бизнестэй холбоотой байж болзошгүй болохыг ХСБ тогтоосон байна. СМА-ны мэдээллээр иргэн Б-г ойролцоогоор 50 гаруй хуулийн этгээдтэй холбоотой, мөн түүний дансанд олон өөр хуулийн этгээд болон хувь хүмүүс бэлэн мөнгөний орлогын гүйлгээ хийсэн болохыг тогтоожээ.

СМА нь мэдээлэх үүрэгтэй этгээдээс иргэн Б-ийн бэлэн мөнгөний орлогын гүйлгээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан дөрвөн СГТ-г хүлээн авсан байна.

СМА-ны хийсэн дүн шинжилгээгээр иргэн Б нь 700,000 долларын гадаад шилжүүлгийг Хонконг, Шинэ Зеланд улс руу хийснийг тогтоосон. Энэхүү гүйлгээг уг иргэний нэр дээр бүртгэлтэй данснаас 400-50,000 доллар хүртэлх дүнгээр гадаад улсын хуулийн этгээдийн данс руу шилжүүлсэн байв. Зарим шилжүүлгийн оффшор бүс дэх мөнгө хүлээн авагчийн нэр нь иргэн Б-ийн төлөөлдөг хуулийн этгээдтэй ижил нэртэй байсан байна.

Иргэн Б-г санхүүгийн гүйлгээ хийхдээ дутуу, буруу мэдээлэл өгсөн гэж буруутгасан бөгөөд тэрээр гэм буруугаа хүлээн зөвшөөрч 9 сарын хорих ял, 2 жилийн тэнсэн харгалзах ял авжээ.

| | |
|----------------------------|--|
| Үйлдсэн гэмт хэрэг | ○ Мөнгө угаах |
| Харилцагч | ○ Аж ахуй нэгж ○ Хувь хүн |
| МҮЭ | ○ Банк |
| Суваг | ○ Цахим ○ Биет |
| Тайлангийн төрөл | ○ ГТТГТ ○ СГТ |
| Харьяалал | ○ Дотоод ○ Гадаад– Шинэ Зеланд, Хонконг |
| Ашигласан үйлчилгээ | ○ Харилцах, хадгаламжийн дансны үйлчилгээ ○ Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ |
| Шалгуур үзүүлэлт | <ul style="list-style-type: none"> ● Гуравдагч этгээдийн дансанд олон удаа дотоодын шилжүүлэг хийсэн; ● Харилцагчийн гүйлгээний хэв маягтай тохирохгүй олон удаагийн гадаад шилжүүлэг хийсэн; ● Гуравдагч этгээд гүйлгээг мэдээлэх доод хязгаараас доогуур дүнгээр бэлэн орлого тушаах зохион байгуулалттай схем (structured cash deposit)-д оролцсон; ● Хувийн болон бизнесийн дансанд гүйлгээг мэдээлэх доод хязгаараас доогуур дүнтэй гүйлгээ хийсэн. |

Кэйс 3 – Бэлэн мөнгө зөөвөрлөгч нь их хэмжээний мөнгийг гадаад улсын зохион байгуулалттай гэмт бүлэглэл рүү шилжүүлснийг илрүүлэв.

ХСБ нь иргэн В-г гадаад улсын зохион байгуулалттай гэмт бүлэглэлд бэлэн мөнгө зөөвөрлөж байсныг тогтоосон бөгөөд СМА-ны мэдээллээр уг иргэн болон бусад бэлэн мөнгө зөөвөрлөгчид нь улс дамжуулан зохион байгуулалттайгаар гэмт хэргээс олсон их хэмжээний мөнгийг угаасан болохыг илрүүлсэн байна.

Гурван иргэнийг баривчилж 11 сарын хорих ял, 12 сарын нийтэд тустай ажил хийх ял, 12 сарын тэнсэн харгалзах ял тус тус оноож 543,000 доллар хураан авчээ.

СМА-ны хийсэн дүн шинжилгээгээр иргэн В болон өөр нэг бэлэн мөнгө зөөвөрлөгч нь их хэмжээний орлого цуглуулж нэгтгэн, гадаад улсын зохион байгуулалттай гэмт бүлэглэл рүү өндөр дүнтэй шилжүүлэг хийсэн болохыг тогтоов.

Гэмт бүлэглэл нь мөнгө угаахдаа дараах аргуудыг ашигласан байна. Үүнд:

- » Иргэн В нь иргэн Г-д хоёр хуулийн этгээдийн данс нээлгэхийг зааварлаж, тухайн дансаар иргэн В нь гүйлгээ хийдэг байв;
- » Иргэн Г нь хууль бус бэлэн мөнгийг авмагцаа иргэн В-тэй холбоо барьж түүнтэй уулзахаар өөр хот руу нисдэг байв;
- » Иргэн В нь иргэн Г-тэй товлосон газраа уулзаж бэлэн мөнгөний орлого хийх, мөнгийг гадаад руу шилжүүлэх зааварчилгаа өгдөг байв;
- » Иргэн Г нь тухайн өдрөө өмнө нь данс нээлгэсэн хуулийн этгээдийн дансанд банкны өөр өөр салбараас олон тооны бэлэн мөнгөний орлогын гүйлгээгээр бэлэн мөнгө тушаадаг байв;
- » Иргэн Г нь иргэн В-ийн заавраар Хонконг дахь хуулийн этгээдийн данс руу мөнгийг шилжүүлнэ;
- » Үүний дараа иргэн Г нь орлогын болон шилжүүлгийн баримтуудыг иргэн В-д өгдөг байна.

СМА нь иргэн Г-ийн 6 сарын хугацаанд хийсэн санхүүгийн үйл ажиллагаанаас дараах сэжигтэй байдлыг илрүүлжээ. Үүнд:

- » Эхний сард иргэн Г нь бизнесийн дансуудаараа өөр муж, хотууд дахь гуравдагч этгээдээс 430,000 гаруй долларын орлого хүлээн авсан;
- » Эхний хоёр сарын хугацаанд иргэн Г нь Хонконг дахь хуулийн этгээдүүд рүү нийт 2.3 сая долларыг шилжүүлсэн;
- » Иргэн Г-ийн хуулийн этгээдийн дансуудад янз бүрийн эх үүсвэрээс их хэмжээний орлого орж, дараа нь гадагшаа мөнгө шилжүүлсэн.

Үүнээс хойших 3 сарын хугацаанд иргэн Г-ийн хуулийн этгээдийн дансуудад 4.8 сая гаруй долларын бэлэн мөнгөний шилжүүлэг оржээ.


Иргэн Г-ийн хуулийн этгээдийн дансуудтай холбоотой, санхүүгийн үйл ажиллагааны цар хүрээг харуулсан дараах СГТ-ууд СМА-нд ирсэн байна:

- » Сар бүр хуулийн этгээдийн дансандаа 100 гаруй удаа өндөр дүнтэй бэлэн орлого, дотоодын цахим шилжүүлэг хүлээн авсан. Зарим орлогыг гуравдагч этгээд хийсэн бөгөөд сар бүрийн нийт орлогын дүн 1 сая гаруй доллар байсан;
- » Сар бүрийн 200,000 орчим долларын орлогыг гүйлгээг мэдээлэх доод хязгаар болох 10,000 доллараас доогуур дүнгээр бэлэн орлого тушаах зохион байгуулалттай схем (structured cash deposit)-ийн дагуу байршуулдаг байсан. Бусад орлогыг 10,000-70,000 орчим долларын дүнгээр тушаадаг байв;
- » Дээрх орлогуудаас бага хувийг нь бэлнээр эсвэл дотоод шилжүүлгээр дамжуулан зарлагадан гаргадаг байв;
- » Харин мөнгөний ихэнх хэсгийг Хонконг дахь хуулийн этгээдүүдэд 10,000-98,000 долларын гүйлгээгээр шилжүүлсэн бөгөөд зарим хүлээн авагч нь валютын ченж байв;
- » Бэлэн зарлага болон дотоод, гадаад шилжүүлгийн гүйлгээг ихэвчлэн дансанд орлого хийсний дараа хийдэг байсан бөгөөд эдгээр гүйлгээнүүд нь харилцагчийн өмнөх гүйлгээний хэв маягтай тохирохгүй байсан.

ХСБ-аас гурван сэжигтнийг баривчилж, 543,000 долларыг хураан авсан байна. Иргэн Г, В нарыг гэмт хэргийн замаар олсон 100,000 доллараас их дүнтэй орлогыг угаахад оролцсон гэж яллажээ.

Иргэн В-д 11 сарын хорих ял, иргэн Г-д 12 сарын нийтэд тустай ажил хийх ял, бусад холбоотой иргэнд 12 сарын тэнсэн харгалзах ял оногдуулсан.

| | |
|----------------------------|---|
| Үйлдсэн гэмт хэрэг | ○ Мөнгө угаах |
| Харилцагч | ○ Аж ахуй нэгж ○ Хувь хүн |
| МҮЭ | ○ Банк |
| Суваг | ○ Цахим ○ Биет |
| Тайлангийн төрөл | ○ СГТ ○ ГТТГТ ○ БМГТ |
| Харьяалал | ○ Дотоод ○ Гадаад– Хонконг |
| Ашигласан үйлчилгээ | ○ Харилцах, хадгаламжийн үйлчилгээ |
| Шалгуур үзүүлэлт | <ul style="list-style-type: none"> • Нэг өдрийн дотор өөр өөр салбарт олон давтамжтай орлого хийсэн; • Хүлээн авсан орлоготойгоо тэнцүү дүнгээр гадаад руу шилжүүлэг хийсэн; • Гүйлгээг мэдээлэгдэхээс зайлсхийж, гүйлгээнүүдийг 10,000 доллараас доош дүнгээр хийсэн; • Харилцагчийн санхүүгийн гүйлгээнд харилцагчийн гүйлгээний хэв маягтай тохирохгүй гэнэтийн их |



Мөнгө угаах типологийн жишээ кэйсүүд

- хэмжээний өөрчлөлт ажиглагдсан;
- Хуулийн этгээдийн дансанд гуравдагч этгээдээс тогтмол бэлэн мөнгө хүлээж авсан;
- Дансанд орлого орсны дараа богино хугацааны дотор шилжүүлэг хийсэн.

Кэйс 4 – Нягтлан бодогчийн зөвлөмжөөр татвараас зайлсхийх үйлдэл хийсэн үйлчлүүлэгч нь хохиров.

Нягтлан бодогчийг хуурамч нэхэмжлэл, хуурамч зээлийн гэрээ ашиглан татвараас зайлсхийх үйл ажиллагаа явуулсныг ХСБ СМА-ны мэдээллээр илрүүлсэн байна. ХСБ нь нягтлан бодогчийн үйлчлүүлэгч нь хуурамч баримт бичиг ашиглан 5 жил хагасын хугацаанд улсад 2 сая долларын татвар төлөхөөс зайлсхийсэн болохыг тогтоожээ.

Нягтлан бодогчид 6 жилийн хорих ял, нягтлан бодогчийн үйлчлүүлэгчид 2-4 жилийн хорих ял оноосон байна.

ХСБ нягтлан бодогч болон түүний хэд хэдэн үйлчлүүлэгч, түүний дотор иргэн Д-д холбогдох хэргийг мөрдөн шалгажээ.

ХСБ нь иргэн Д-г импортын бизнес эрхэлдэг бөгөөд нягтлан бодогчийн санал болгосны дагуу дараах хуулийн этгээдийг ашиглан татвараас зайлсхийсэн болохыг тогтоосон байна. Үүнд:

- » Компани 1 - иргэн Д болон түүний эхнэр нь Компани 1-ийн хувьцаа эзэмшигч, захирал;
- » Компани 2 – иргэн Д нь өөр нэг иргэнтэй хамтран Компани 2-ийг өмчилдөг, өөрөө захирлаар нь ажилладаг;
- » Компани 3 – Нягтлан бодогч Компани 3-ийг удирддаг бөгөөд энэ компани нь Хонконгт бүртгэлтэй, тус улсад банкны данстай. Компани 3 нь Компани 1, 2-т хуурамч нэхэмжлэл гаргаж өгдөг байсан.

Хуурамч нэхэмжлэл

Компани 3 нь 5 жил 6 сарын хугацаанд Компани 1, 2-т "зуучлалын үйлчилгээ үзүүлсний төлбөр" гэх утгатай хуурамч нэхэмжлэл гаргаж өгсөн байна. Уг нэхэмжлэлийн дагуу Компани 1, 2 нь тус бүр 1 сая доллар, нийт 2 сая долларыг Компани 3-т дотоод шилжүүлэг хийх замаар, мөн чекээр төлсөн.

Тус төлбөр нь Компани 3-ын зуучлалын үйлчилгээ үзүүлсний төлбөр гэж хийгдсэн байсан боловч мөрдөн шалгах ажиллагаагаар Компани 3 нь зуучлалын үйлчилгээ үзүүлдэггүй болох нь тогтоогджээ.

Компани 1, 2 нь дээр дурдсан мөнгийг Компани 3-т зуучлалын үйлчилгээ үзүүлсний төлбөр гэж төлснөөр татвар ногдох орлогоо хууль бусаар бууруулж, бага татвар төлсөн байна.

Хуурамч зээл

Компани 3-т төлсөн мөнгөнөөс нягтлан бодогч 10 хувийг авч үлдээд бусдыг нь иргэн Д болон түүнтэй холбоотой хүмүүс рүү буцаан шилжүүлдэг байжээ. Мөн 5 жил зургаан сарын хугацаанд Компани 3 болон нягтлан бодогчийн удирддаг эсхүл төлөөлдөг бусад компаниуд Компани 1, 2-т 1.8 сая орчим доллар буцаан шилжүүлжээ.

Иргэн Д рүү мөнгийг дараах байдлаар шилжүүлсэн байна. Үүнд:

- » Иргэн Д-тэй Компани 2-ийг хамтран өмчилдөг иргэнд олгосон зээл гэж 100,000 доллар;
- » Иргэн Д-гийн эхнэрт 200,000 доллар;
- » Иргэн Д-д зээл олгов гэж 1.5 сая долларыг тус тус шилжүүлжээ.

СМА-ны дүн шинжилгээгээр иргэн Д-ийн Япон улс дахь банкны данс руу Компани 3-аас 2 удаагийн гүйлгээгээр нийт 270,000 долларын гүйлгээг “зээл” гэх утгаар халхавчлан шилжүүлснийг илрүүлсэн байна.

Иргэн Д нь 1.5 сая долларыг Компани 3 болон нягтлан бодогчийн эзэмшиж, удирддаг, Британийн Виржиний арлуудад бүртгэлтэй компани (Компани 4)-иас авсан "зээл" гэж мэдүүлсэн. Гэвч ХСБ үүнийг нотлох бичиг баримт олоогүй байна, түүнчлэн Компани 4-өөс иргэн Д-гийн банкны дансанд ямар ч шилжүүлэг хийгдэж байгаагүй бөгөөд Компани 4 нь тус улсад банкинд данс эзэмшдэггүй, бэлэн мөнгөний орлогын гүйлгээ хийж байгаагүй байна.

Мөн СМА-ны мэдээллээс иргэн Д болон Компани 2 нь 3 жилийн хугацаанд Япон улс руу нийтдээ 1 сая долларын гүйлгээ шилжүүлсэн бөгөөд хүлээн авагчид нь өөрсдөө байсныг тогтоосон байна.

ХСБ иргэн Д-г татвараас зайлсхийх зорилгоор Япон улс руу эдгээр шилжүүлгийг хийсэн бөгөөд Компани 1, 2-оос Компани 3-т хуурамч төлбөр шилжүүлж, татвар төлөөгүй мөнгө буцаан авсан гэж үзсэн.

ХСБ нь иргэн Д-г нягтлан бодогчийн компаниудаас буцааж хүлээн авсан 400,000 доллароор байшиндаа засвар хийх, орон сууцны зээлийн төлбөр төлөх, амьжиргааны зардалдаа зарцуулсан болохыг тогтоожээ.

Орлого, татварын зөрүү

ХСБ нь иргэн Д-ийн орлогын татварын тайланд дүн шинжилгээ хийсэн бөгөөд түүнийг тухайн жилийн орлогоо 30,000 доллар гэж тайлагнасан болохыг тогтоожээ. Тухайн санхүүгийн жилд иргэн Д нь 400,000 долларыг хувийн дансандаа хадгалж, 450,000 долларыг данснаас авсан байв.

Мөн дараагийн 3 жилийн хугацаанд иргэн Д нь нийт орлогоо жилд 30,000 доллар гэж мэдүүлсэн боловч Компани 3-аас авсан 1.5 сая доллароо мэдүүлээгүй байв.

ХСБ нь нягтлан бодогч болон иргэн Д-ийн гэр орон, бизнесийн үйл ажиллагаа явуулдаг байруудад нэгжлэг явуулж холбогдох нотлох баримтуудыг олж авсан байна.


Хариуцлага

Иргэн Д-г 4 жилийн хорих ял болон 1 сая долларын торгууль төлөх ялаар шийтгэсэн байна.

Нягтлан бодогч нь залилангийн үйлдэлд тусалсан хэргээр яллагдаж 6 жилийн хорих ял, мөн нягтлан бодогчийн бусад гурван үйлчлүүлэгч нь хууран мэхлэх замаар санхүүгийн ашиг хонжоо олсон хэрэгт яллагдаж 2-3 жилийн хорих ялаар тус тус шийтгэгдсэн байна.

| | |
|----------------------------|---|
| Үйлдсэн гэмт хэрэг | ○ Татвараас зайлсхийх |
| Харилцагч | ○ Гадаадын хуулийн этгээд ○ Хувь хүн ○ Аж ахуй нэгж |
| МҮЭ | ○ Банк |
| Суваг | ○ Цахим |
| Тайлангийн төрөл | ○ ГТТГТ |
| Харьяалал | ○ Гадаад- Их Британы Виржиний арлууд, Хонконг, Япон |
| Ашигласан үйлчилгээ | ○ Харилцах, хадгаламжийн үйлчилгээ |
| Шалгуур үзүүлэлт | <ul style="list-style-type: none"> ● Харилцагч нь гадаад гүйлгээний шилжүүлэгч, хүлээн авагч байсан; ● Харилцагч нь зээл гэсэн утгатай гадаад гүйлгээ хүлээн авсан; ● Харилцагч нь бизнесийн ямар нэгэн үндэслэлгүйгээр нарийн төвөгтэй шилжүүлэг хийсэн; ● Тодорхой шалтгаангүйгээр их хэмжээний шилжүүлэг хийсэн; ● Төвөгтэй гүйлгээнүүдийг далдлахын тулд нягтлан бодогчийг ашигласан; ● Татварын нууцлал өндөртэй улс орон ашигласан. |

Зураг 2: Кэйс 4- Нягтлан бодогчийн зөвлөмжөөр татвараас зайлсхийх үйлдэл хийсэн үйлчлүүлэгч нь хохиров.



Кэйс 5 – Татвар ногдуулах орлогоо нуун дарагдуулж, хөрөнгөө Кипр, Гибралтар улсад нуужээ.

ХСБ-ууд иргэн Ж, 3 нарын татвар ногдуулах орлогоо нуун дарагдуулах зорилгоор хөрөнгөө оффшор бүс дэх банкны данс болон Кипр, Гибралтар улс руу шилжүүлснийг СМА-ны мэдээллийг ашиглан илрүүлэв. Энэ үйл ажиллагаанд оффшор бүс дэх тэтгэврийн сан болон зээлийн хуурамч гэрээг ашигласан байна.

ХСБ-ууд энэ хэргийг илрүүлснээр татварт орлогоо дутуу тайлагнасан этгээдийг илрүүлж, 2 сая гаруй долларын татвар, торгуулийг нэмж нэхэмжилсэн байна.

Татвараас зайлсхийсэн дээрх хэргийг дараах арга замаар үйлдсэн байна. Үүнд:

- » **1 дүгээрт:** Оффшор бүс дэх тэтгэврийн сан руу гадаад шилжүүлэг хийж, богино хугацааны дотор буцаан шилжүүлж авсан;
- » **2 дугаарт:** хуурамч зээлийн гэрээний дагуу 10 жилийн турш гадаад шилжүүлэг хийж байсан;
- » **3 дугаарт:** ЦЖБ ХХК татан буугдахад зээлийн гэрээг нь өөр нэг компанид шилжүүлсэн /энэ схем цаашид дахин 4 жилийн хугацаанд үргэлжилсэн/;
- » **4 дүгээрт:** Зээлийн гэрээ буяны байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон.

Иргэн Ж болон 3 нь автомашины засвар, борлуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд өмчлөгчид бөгөөд гэр бүлийн гишүүд байв.

Арга 1 – Оффшор бүс дэх тэтгэврийн сан

Иргэн Ж, 3 нар нь нягтлан бодогчоос оффшор бүс дэх тэтгэврийн санг хэрхэн ашиглах талаар зөвлөгөө авсан бөгөөд үүний дараа иргэн Ж нь Кипр улсад тэтгэврийн сан үүсгэн байгуулж, Кипр улсад бүртгэлтэй компанийг уг сангийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилон ажиллуулсан.

Иргэн Ж болон 3 нь ЦЖБ ХХК-ийг эзэмшдэг бөгөөд энэ компани нь Кипр улс дахь тэтгэврийн санд хөрөнгө оруулж, 100,000 долларыг 2 удаагийн гүйлгээгээр найман өдрийн зайтай Кипр улсын банк руу шилжүүлсэн.

Кипр улсын банкнаас 200,000 долларыг ЦЖБ ХХК-нд 100,000 доллараар 2 удаагийн гүйлгээгээр буцаан шилжүүлжээ. Шилжүүлгийг тэтгэврийн санд хөрөнгө оруулснаас хойш нэг сарын дараа хийсэн бөгөөд үүнийг ЦЖБ ХХК-нд банкнаас олгосон 'зээл' гэж тайлбарласан боловч эдгээр шилжүүлгийг батлах зээлийн гэрээ байгаагүй болно.

ЦЖБ ХХК нь тэтгэврийн санд оруулсан 200,000 долларын хөрөнгө оруулалтаа татвар ногдуулах орлогоос хасагдах зардалд тооцуулж, бага татвар төлж татвараас зайлсхийжээ.

Энэ хэргийг илрүүлсний дараа татварын байгууллага ЦЖБ ХХК-ийг татвар ногдуулах орлогыг нуун дарагдуулсан гэж үзсэн бөгөөд татвар ногдох орлогыг дахин тооцож зардлын хасалтыг хүчингүй болгосон.

Зураг 3: Кэйс 5 – Татвар ногдуулах орлогоо нуун дарагдуулж, хөрөнгөө Кипр, Гибралтар улсад нуужээ.



Арга 2 - Зээл


Иргэн Ж болон З нь Кипр улсын банктэй ЦЖБ ХХК-ийн нэрийн өмнөөс зээлийн гэрээ байгуулсан (энэ гэрээ нь Арга 1-д дурдсан 200,000 долларын зээлтэй хамааралгүй болно). Энэ зээлийн гэрээ нь 10-аас дээш жил хүчинтэй байсан бөгөөд дараа нь өөр компаниудад шилжжээ.

Кипр улсын банкны охин компани нь Гибралтар улсад банкны данстай бөгөөд Кипр улсын банк ба Иргэн Ж, З-тэй холбоотой компани, хувь хүмүүсийн хооронд төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн.

Зээлийн гэрээний дагуу Иргэн Ж, З-ийн компаниуд нь Кипр улсын банк эсвэл түүний охин компанид жил болгон зээлийн хүүний төлбөрийг шилжүүлдэг байв. Хүлээн авсан хүүний төлбөрийг Кипр улсын банк эсвэл түүний охин компани нь буцаагаад ЦЖБ ХХК рүү эсвэл холбоотой бусад компани, хувь хүмүүс рүү шилжүүлсэн бөгөөд үүнийгээ “зээл, зээлийн шугамын хэрэглээ шилжүүлсэн” гэж тайлбарлажээ.

Татвараас зайлсхийх энэхүү ажиллагаа нь санхүүгийн гүйлгээг зээлтэй холбоотой хууль ёсны гүйлгээ мэт харагдуулан нуун далдлах зорилготой байсан бөгөөд бодит байдал дээр гадаад руу шилжүүлсэн мөнгө эцсийн дүндээ ЦЖБ ХХК болон холбоотой бусад компаниуд руу буцаж ирдэг байв.

Зураг 4: Кэйс 5- Гибралтар дахь охин компанийн банкны дансаар хийгдсэн шилжүүлгүүд



Арга 3. ЦЖБ ХХК-иас ТФР ХХК руу шилжсэн зээлийн гэрээ

ЦЖБ ХХК нэрээ сольсныхоо дараа татан буугдсан бөгөөд үүний улмаас татварын байгууллага тус компанийн 800,000 долларын хуримтлагдсан татварын өрийг авч чадахгүй болов.

ЦЖБ ХХК татан буугдсаны дараа зээлийн өр төлбөрийг ТФР ХХК-нд шилжүүлсэн бөгөөд зээлийн өр төлбөр нь ойролцоогоор 3 сая доллар болсон байв.

ТФР ХХК нь Кипр улсын банк болон түүний охин компанид зээлийн хүүний төлбөрийг төлөх замаар үргэлжлүүлэн татвараас зайлсхийж байв. ТФР ХХК нь банкинд хүүний төлбөр хийх болгонд тус банкны охин компани нь ТФР ХХК-ны данс руу мөнгө буцаан шилжүүлж, шилжүүлгээ зээлийн шугамын хэрэглээ гэж тайлбарлаж байв.

СМА-ны мэдээлэл болон ХСБ-уудын цуглуулсан мэдээллээр ТФР ХХК болон Гибралтар дахь охин компанийн данс хооронд 4 жилийн турш хийгдсэн гадаад гүйлгээнүүдийг илрүүлжээ.

ТФР ХХК нь "зээл" хэлбэрээр авсан хөрөнгийг дотоодын компаниудад хүүгүй зээл хэлбэрээр олгосон гэж мэдүүлсэн байна.

Арга 4. Буяны байгууллагын оролцоо


Татвар ногдуулах орлогоо нуун дарагдуулах зорилгоор хуурамч зээлийн үйл ажиллагаанд холбоо хамааралгүй буяны байгууллагыг татан оролцуулсан. Энэ буяны байгууллага нь Гибралтар дахь охин компани болон холбоотой бусад компаниудын хооронд мөнгө шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийж гүйцэтгэдэг болжээ.

ХСБ-уудын мэдээлэл болон СМА-ны мэдээллээс дараах дүр зураг гарсан. Үүнд:

- » ТФР ХХК нь “хүүний төлбөр” гэх мөнгийг Гибралтар дахь охин компанийн данс руу шилжүүлсэн;
- » Охин компани нь “хүүний төлбөр”-тэй ижил дүнтэй мөнгийг буяны байгууллагын данс руу шилжүүлсэн бөгөөд шилжүүлгийг “зээлийн шугам” болон “мөнгөн шилжүүлэг” гэсэн утгатай шилжүүлдэг байсан;
- » буяны байгууллага дээрх шилжүүлгийг хүлээн авснаас 4-5 хоногийн дараа ТФР ХХК-ийн данс руу “зээл” гэсэн утгатайгаар шилжүүлэг хийдэг байв.

Зураг 5-т ТФР ХХК, Гибралтар дахь охин компани, буяны байгууллагын хооронд хийгдсэн гүйлгээний чиглэл, мөнгөн дүнгийн хэмжээг харуулав.

Зураг 5: Кэйс 5- Буяны байгууллагыг ашиглаж мөнгө шилжүүлсэн байдал



ТФР ХХК нь татварын тайландаа Кипр улсын банкны хүүгийн төлбөрийг зардлаар бүртгэдэг байв. Энэ зардлыг хасуулснаар ТФР ХХК нь татвар ногдох орлогоо бууруулж, төлөх ёстой татвараасаа доогуур дүнтэй татвар төлж, татвараас зайлсхийсэн байна.

Энэ хэргийг илрүүлсний дараа татварын байгууллага ТФР ХХК-ийг татвар ногдуулах орлогыг нуун дарагдуулсан гэж үзсэн бөгөөд татвар ногдох орлогыг дахин тооцон

зардлын хасалтыг хүчингүй болгож, 2 сая долларын татвар, торгуулийг нэмж ногдуулсан.

| | |
|----------------------------|---|
| Үйлдсэн гэмт хэрэг | ○ Татвараас зайлсхийх |
| Харилцагч | ○ Гадаадын хуулийн этгээд ○ Хувь хүн ○ Аж ахуй нэгж |
| МҮЭ | ○ Банк |
| Суваг | ○ Цахим |
| Тайлангийн төрөл | ○ ГТТГТ |
| Харъяалал | ○ Гадаад – Кипр улс, Гибралтар улс |
| Ашигласан үйлчилгээ | ○ Харилцах, хадгаламжийн үйлчилгээ |
| Шалгуур үзүүлэлт | <ul style="list-style-type: none"> ● Харилцагч нь гадаад гүйлгээгээр зээлийн урьдчилгаа болон зээл гэсэн утгатай гүйлгээг хүлээн авсан; ● Харилцагч нь тодорхой бизнесийн зорилгогүй нарийн төвөгтэй гүйлгээнүүдийг хийсэн; ● Өндөр эрсдэлтэй улс орнуудаас гадаад гүйлгээ хүлээн авсан; ● Тодорхой шалтгаангүйгээр өндөр дүнгээр гадаад шилжүүлэг хийсэн; ● Оффшор бүс рүү шилжүүлэг хийсний дараа ижил оффшор бүсээс ижил дүнтэй шилжүүлэг хүлээн авсан; ● Бизнесийн холбоо хамааралгүй буяны байгууллагыг ашигласан; ● Гүйлгээг нарийн, төвөгтэй болгох үүднээс тулд гуравдагч этгээдийн данс ашигласан; ● Гуравдагч этгээд эсвэл гэр бүлийн гишүүдийн данс ашигласан. |

Кэйс 6 - Гэмт хэргийн бүлэглэлийн үйлдсэн зээлийн картын залилангийн хэрэг.

СМА-ны СГТ-ийн мэдээллийг ашиглан ХСБ хууль бус санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулалттай үйлдсэн гэмт бүлэглэлийг илрүүлэн, зээлийн картын залилангийн хэргийг таслан зогсоосон байна.

Гэмт бүлэглэлийн 2 гишүүнийг залилангийн хэрэгт яллаж, нэг нь 2 жил 3 сарын хорих ял, нөгөө нь 12 сарын хорих ял авжээ.

Зохион байгуулалттай гэмт бүлэглэл нь оюутнуудыг сургуульд зуучлах үйл ажиллагааг зохион байгуулдаг компанитай байсан бөгөөд тухайн компанийг зээлийн картын залилан хийх зорилгоор мөн ашигласан байв. Гэмт бүлэглэл нь амархан борлуулагдах боломжтой өндөр үнэтэй бараа бүтээгдэхүүнийг хууль бусаар худалдан авахад туслуулах зорилгоор их хэмжээний өртэй М улсын иргэдийг элсүүлэн авсан байна.

Гэмт бүлэглэлд элссэн иргэд хуурамч бичиг баримт, хуурамч нэр ашиглан албан ёсны иргэний үнэмлэх, жолооны үнэмлэх г.м бичиг баримт гаргуулан авч, банкинд данс нээлгэн зээл авсан байна.

Мөн гэмт бүлэглэл нь дээрх иргэдэд хуурамч зээлийн карт өгдөг байв. Бүлэглэлд элссэн иргэд нь худалдааны төвүүдээс зөөврийн компьютер, цахилгаан бараа, хөгжим, үнэт эдлэл, дэлгүүрийн бэлгийн карт, үнэтэй согтууруулах ундаа гэх мэт өндөр үнэтэй бараа бүтээгдэхүүнүүдийг худалдаж авдаг байв. Эдгээр иргэдийн авчирсан бараа бүтээгдэхүүнийг гуравдагч этгээдэд бэлнээр борлуулдаг бөгөөд тэдэнд олсон орлогын тодорхой хувийг өрийг нь төлөхөд зориулж өгдөг байв.

СМА-ны мэдээллийг тус бүлэглэлд элссэн иргэдийг тодорхойлох, тэдгээрийн хийсэн гадаад төлбөр тооцооны гүйлгээнүүдийг илрүүлэхэд ашигласан байна. Мөн СМА-нд мэдээлсэн хэд хэдэн СГТ нь гэмт бүлэглэлийн хууль бус санхүүгийн үйл ажиллагааг илрүүлэхэд тусалсан байна. СМА-ны дүн шинжилгээ, хууль сахиулах байгууллагын мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд бүлэглэлийн гишүүд нь гэмт хэргээс олсон орлогын тодорхой хэсгийг үл хөдлөх хөрөнгө худалдаж авахад зориулж, бусад хөрөнгийг казиногоор дамжуулан угаасан болохыг тогтоосон байна.

Казиногоос ирүүлсэн СГТ-аас бүлэглэлийн нэг гишүүн 32,000 долларын казиногийн чипийг бэлэн мөнгө болгон хөрвүүлж авсан бөгөөд ингэхдээ казинод бооцоо тавиагүй, хамааралгүй иргэний бичиг баримт ашигласан болох нь илэрчээ.


Мөн дээрх хүн өмнө нь гүйлгээ хийхдээ казиногийн өөр өөр үнэмлэх үзүүлсэн болохыг тогтоожээ. СМА-нд мэдээлсэн БМГТ-нд тухайн хүнийг 14 сарын хугацаанд 4 удаа нийт 59,000 долларын тоглоомын чипийг бэлэн мөнгөөр солиулсан мэдээлэл бүртгэгдсэн байв.

Бүлэглэлийн хоёр гишүүнийг залилангийн гэмт хэрэгт яллаж, нэгэнд нь 2 жил 3 сарын хорих ял, нөгөөд нь 12 сар хорих ял оноожээ.

Мөнгө угаах типологийн жишээ кэйсүүд

| | |
|----------------------------|---|
| Үйлдсэн гэмт хэрэг | <ul style="list-style-type: none"> ○ Залилан ○ Мөнгө угаах |
| Харилцагч | <ul style="list-style-type: none"> ○ Байгууллага ○ Хувь хүн |
| МҮЭ | <ul style="list-style-type: none"> ○ Банк ○ Казино |
| Суваг | <ul style="list-style-type: none"> ○ Цахим ○ Биет |
| Тайлангийн төрөл | <ul style="list-style-type: none"> ○ СГТ ○ ГТТГТ ○ БМГТ |
| Харъяалал | <ul style="list-style-type: none"> ○ Дотоод ○ Гадаад |
| Ашигласан үйлчилгээ | <ul style="list-style-type: none"> ○ Харилцах, хадгаламжийн үйлчилгээ ○ Казино |
| Шалгуур үзүүлэлт | <ul style="list-style-type: none"> • Нэг өдрийн дотор олон төрлийн казиногийн чипийг бэлэн мөнгөөр солиулсан; • Казинод бага тоглоод их хэмжээний чипийг бэлэн мөнгөөр солиулсан; • Хуурамч баримт, бичиг ашигласан. |

Зураг 6: Кэйс 6 - Гэмт хэргийн бүлэглэл нь зээлийн картын залилангийн хэрэгт М улсын иргэдийг элсүүлжээ.



Кэйс 7 –2 сая долларын залилангийн хохирогчийг тогтоов.

Залилангийн хэрэг үйлдсэн зохион байгуулалттай олон улсын гэмт бүлэглэлд 2 сая долларын "урьдчилгаа төлбөр" шилжүүлсэн хохирогчийг СМА-ны мэдээллээр олж тогтоосон байна.

Энэхүү мэдээллийг ашиглан ХСБ хохирогчийг илрүүлж, олон улсын гэмт бүлэглэлд дахин мөнгө илгээхээс сэргийлсэн байна.

СМА-ны ГТТГТ-нд хийсэн дүн шинжилгээгээр иргэн Л нь Гана, Ливан, Малайз, Нигери, Испани, Их Британи зэрэг улсуудын олон тооны иргэдэд нийт 1.2 сая доллар шилжүүлсэн болохыг тогтоосон байна. Иргэн Л шилжүүлэг хийхдээ мөнгөн шилжүүлгийн олон өөр төрлийн үйлчилгээ болон банкны гадаад гуйвуулгын үйлчилгээг ашиглан нэг удаад 200-123,000 доллар шилжүүлдэг байжээ.

СМА мөн холбогдох хэд хэдэн СГТ-нг хүлээн авсан бөгөөд СГТ-д дараах мэдээлэл дурдагдсан байв:

- » Тухайн иргэн Египет, Ливан, Нигери, Испани, Шри Ланка, Их Британи улсын хүлээн авагчдад их хэмжээний мөнгө шилжүүлж байсан бөгөөд ингэхдээ бэлэн мөнгө ашигласан байна;
- » Гадаад гүйлгээний дүн нь 700-8,500 долларын хооронд байсан;
- » Мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашигласан.

ХСБ СМА-ны мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тухайн иргэнийг залиланд өртсөн байж болзошгүйг тогтоон, түүнтэй холбогдож залилангийн гэмт хэрэгт өртсөн байж болзошгүй гэдгийг нь мэдэгдсэн бөгөөд гадаад руу дахин мөнгө илгээхгүй байхыг анхааруулсан байна.

Иргэн Л нь Их Британи улсаас 32 сая фунт стерлингийн хөрөнгө өвлөж авахын тулд “хураамж”, “татвар” гэх төлбөрт нийтдээ 2 сая долларыг залилагчдад шилжүүлсэн байжээ.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад иргэн Л нь гадаадад байгаа залилагчидтай цахимаар харилцаж залилуулсан болохыг тогтоожээ.

ХСБ түүнтэй холбоо барьсны дараа иргэн Л мөнгө шилжүүлэхээ зогсоосон бөгөөд энэ хэрэг нь олон улсын гэмт бүлэглэл зохион байгуулалттайгаар иргэдийг залилан мэхлэх үйлдэл хийж байсныг таслан зогсооход СМА-ны мэдээллийг үр дүнтэй ашигласан нэгэн жишээ болов.

Мөнгө угаах типологийн жишээ кэйсүүд

| | |
|----------------------------|--|
| Үйлдсэн гэмт хэрэг | ○ Залилан |
| Харилцагч | ○ Хувь хүн |
| МҮЭ | ○ Банк |
| Суваг | ○ Цахим ○ Биет |
| Тайлангийн төрөл | ○ ГТТГТ ○ СГТ |
| Харьяалал | ○ Гадаад - Египт, Гана, Ливан, Малайз, Нигери, Испани, Шри Ланк, Их Британи улс |
| Ашигласан үйлчилгээ | ○ Харилцах, хадгаламжийн үйлчилгээ ○ Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ |
| Шалгуур үзүүлэлт | <ul style="list-style-type: none">• Тодорхой шалтгаангүйгээр их хэмжээний гадаад шилжүүлэг хийсэн;• Өндөр эрсдэлтэй улс орнууд руу гадаад шилжүүлэг хийсэн. |